

Үндэсний Статистикийн Газар батлав.
2003 он Тушаал № 228

Аймаг, нийслэл

Сум, дүүрэг.....

- Улсын тайлан маягт НС-1
- Сум, дүүргийн Засаг даргын тамгын газар гаргаж, 12-р сарын 5-нд аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс /тасаг/-т
 - Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс / тасаг/ 12-р сарын 21-нд теле холболтоор ҮСГ-т ирүүлнэ.

ӨРХ, ХҮН АМЫН НИЙГМИЙН
ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТИЙН
20 ... ОНЫ ТАЙЛАН

1.ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО

А	м/д	БҮГД	Үүнээс: насны бүлгээр			
			0-6	7-9	10-15	16-18
Б	1	2	3	4	5	
Бүтэн өнчин хүүхдийн тоо	1					
Үүнээс: эрэгтэй	2					
эмэгтэй	3					
Хагас өнчин хүүхдийн тоо	4					
Үүнээс: эрэгтэй	5					
эмэгтэй	6					

Хийх шалгалт: Мөр: Бүгд 1=2+3; 4=5+6
Багана: Бүгд 1=2+3+4+5

2.ОНЦ ХҮНД НӨХЦӨЛД БАЙГАА ХҮҮХДИЙН ТОО

А	м/д	БҮГД	Үүнээс: насны бүлгээр			
			0-6	7-9	10-15	16-18
Б	1	2	3	4	5	
Байгалийн гамшигт өртсөн хүүхэд	7					
Зам тээврийн болон ахуйн осолд өртсөн хүүхэд	8					
Халдварт өвчин, тахалд нэрвэгдсэн хүүхэд	9					
Амиа хорлох оролдлого хийсэн	10					

Багана: Бүгд 1=2+3+4+5

3.16 ХҮРТЭЛ НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ, ГЭР БҮЛГҮЙ ХҮНИЙ ТОО

А	м/д	БҮГД	Үүнээс: хүүхдийн тоогоор		
			3 хүртэл	3-5	6 ба түүнээс дээш
Б	1	2	3	4	
Хүүхэдтэй, гэр бүлгүй-бүгд	11				
эхийн тоо	12				
эцгийн тоо	13				
Бүгдээс: хөдөөд	14				
эхийн тоо	15				
эцгийн тоо	16				

Мөр: Бүгд 11=12+13; 14=15+16
Багана: Бүгд 1=2+3+4
Хөдөөд сумын төв, хөдөө (баг) орно.

4. ӨРХ ТОЛГОЙЛСОН ХҮНИЙ ТОО

	м/д	БҮГД	Үүнээс		Бүгд үүнээс: ам бүлийн тоогоор		
			хот	хөдөө	3 хүртэл	3-5	6 ба дээш
А	Б	1	2	3	4	5	6
Өрх толгойлсон-бүгд	17						
Үүнээс: эрэгтэй	18						
эмэгтэй	19						

Мөр: Бүгд $17=18+19$

Багана: Бүгд $1=2+3$; $1=4+5+6$

5. ӨРХИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

	м/д	БҮГД	Үүнээс:	
			хот	хөдөө
А	Б	1	2	3
8 ба түүнээс дээш ам бүлтэй өрхийн тоо	20			
16 хүртэл насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо	21			
Ганц бие өрхийн тоо-бүгд	22			
Үүнээс: эрэгтэй (60 ба түүнээс дээш настай)	23			
эмэгтэй (55 ба түүнээс дээш настай)	24			
Тэтгэвэр, тэтгэмж тогтоогдоогүй өндөр настай хүний тоо-бүгд	25			
Үүнээс: эрэгтэй (60 ба түүнээс дээш настай)	26			
эмэгтэй (55 ба түүнээс дээш настай)	27			

Мөр: Бүгд $22=23+24$; $25=26+27$

Багана: Бүгд $1=2+3$

6. ТАХИР ДУТУУ ХҮНИЙ ТОО

	м/д	БҮГД	Үүнээс: эмэгтэй	Тахир дутуугийн шалтгаан				
				Төрөлхийн	Олдмол			
					Өвчнөөр		Осол гэмтлээр	
				Ердийн өвчин	МШӨ	Ахуйн осол	Үйлдвэр-ийн осол	
А	Б	1	2	3	4	5	6	7
Тахир дутуу хүний тоо - бүгд	28							
Үүнээс: 0-16 настай	29							
Хөдөлмөрийн насны (16-54 насны эмэгтэй, 16-59 насны эрэгтэй)	30							
Хөдөлмөрийн нас хэтэрсэн (55, дээш насны эмэгтэй, 60, дээш насны эрэгтэй)	31							
Бүгдээс: Харах эрхтний өөрчлөлттэй	32							
Үүнээс: хүүхэд (0-16 нас)	33							
Сонсгол, хэл ярианы согогтой	34							
Үүнээс: хүүхэд (0-16 нас)	35							
Хөдөлгөөний согогтой	36							
Үүнээс: хүүхэд (0-16 нас)	37							
Оюун ухааны хомсдолтой	38							
Үүнээс: хүүхэд (0-16 нас)	39							
Сэтгэцийн эмгэгтэй	40							
Үүнээс: хүүхэд (0-16нас)	41							
Хавсарсан согогтой	42							
Үүнээс: хүүхэд (0-16нас)	43							
Бусад	44							

МШӨ - Мэргэжлээс шалтгаалах өвчний
 Мөр: Бүгд 28=29+30+31; 28=32+34+36+38+40+42+44
 Багана: 1=3+4+5+6+7

Тайлан гаргасан:

.....
 /Албан тушаал/

.....
 /Гарын үсэг/

/...../
 /Нэр/

Тайланг хянасан:

.....
 /Албан тушаал/

.....
 /Гарын үсэг/

/...../
 /Нэр/

200.... оны сарын өдөр

Өрх, хүн ам нийгмийн зарим үзүүлэлтийн
(Маягт НС-1) тайланг нөхөх аргачлал, заавар

Өрх хүн амын нийгмийн үзүүлэлтийн тайлангаар хүн амын нийгмийн асуудлыг зохицуулах зарим арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэхэд үндэслэл болох тоо материал бүрдүүлэх зорилготой. Тайланг жил бүрийн 12-р сарын 1-ний байдлаар сум, дүүргийн Засаг даргын тамгын газар гаргаж, мөн сарын 5-ний дотор аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс/тасаг/-т хүргүүлнэ. Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс/тасаг/ тайланг шалгаж нэгтгэн Үндэсний Статистикийн Газарт теле холболтоор дамжуулна.

Хүснэгт 1. Өнчин хүүхдийн тоо

Бүтэн, хагас өнчин хүүхдийн тоог тодорхойлно. Бүтэн өнчинд эцэг, эх нь 2-лаа нас барсан хүүхдийг, хагас өнчинд эцэг, эх 2-ын аль нэг нь нас барсан хүүхдийг оруулж бүртгэнэ. Бутач хүүхэд, гэр бүл салалтын улмаас эцэг, эхийн аль нэгтэй хамт амьдарч байгаа хүүхдийг өнчин хүүхэдэд оруулахгүй.

Хүснэгт 2. Онц хүнд нөхцөлд байгаа хүүхдийн тоо

“Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” Монгол Улсын хуулийн 15 дугаар зүйлийн 1-д “Байгалийн гамшиг, гоц халдварт өвчин, нийтийг хамарсан гэнэтийн осол, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн, амиа хорлох оролдлого хийсэн хүүхдийг онцгой нөхцөлд байгаа хүүхэд гэж үзнэ” гэж тодорхойлсон байдаг. Энэ заалтын дагуу онцгой хүнд нөхцөлд байгаа хүүхдийн тоог гаргана.

Хүснэгт 3. 16 хүртэл насны хүүхэдтэй, гэр бүлгүй хүний тоо

Гэр бүлгүй, 16 хүртэл насны хүүхэдтэй эрэгтэй болон эмэгтэй хүнийг эцэг эх, хамаатан садангийн хэнтэй хамт амьдардагийг харгалзахгүйгээр хамруулж гаргах бөгөөд үүнээс хөдөөд байнга оршин суугчдыг сугалж харуулна. Хөдөөгийн хүн амд сумын төв болон хөдөөд оршин суугаа хүн ам орно. Аймгийн төв, тосгоны хүн ам нь хотын хүн амд орно.

Хүснэгт 4. Өрх толгойлсон хүний тоо

Энэхүү хүснэгтээр гэр бүлгүй өрхийн тэргүүлэгчдийн тоог хүйсээр ялгаж гаргана. Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоонд хүүхэдтэй эсэхийг үл харгалзан эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоог авч бүртгэнэ. Эрэгтэй тэргүүлэгчтэй өрхөд гэр бүлгүй, өрхөө толгойлон амьдарч байгаа эрэгтэйчүүдийг хүүхэдтэй эсэхийг харгалзахгүйгээр хамруулна. Энэ үзүүлэлтүүдийг хот, хөдөөгөөр болон ам бүлийн тоогоор гаргана.

Хот тосгоны эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хуулинд “Хот нь 15000-аас доошгүй оршин суугчтай, тэдгээрийн дийлэнх хувь нь голлон үйлдвэр, үйлчилгээний салбарт ажилладаг, хот бүрдүүлэгч дэд бүтэц хөгжсөн, өөрийн удирдлага бүхий төвлөрсөн суурин газар мөн”,

“Тосгон нь 500-15000 оршин суугчтай, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, аялал жуулчлал, амралт, сувилал, тээвэр, худалдаа зэрэг салбарын аль нэг нь хөгжсөн, өөрийн удирдлага бүхий суурин газар мөн” гэж тус тус тодорхойлсон байдаг. Дээрхи хот, тосгоны тодорхойлолтуудад хамаарагдахгүй хүн амыг хөдөөгийн хүн ам гэж үзнэ.

Хотод нийслэл, аймгийн төв, тосгон; хөдөөд сумын төв, хөдөө (баг) орно.

Хүснэгт 5. Өрхийн зарим үзүүлэлт

Энэ хүснэгтээр 8 ба түүнээс дээш ам бүлтэй өрх, 16 хүртэл насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх, мөн өндөр настай ганц бие өрх, тэтгэвэр, тэтгэмж тогтоогдоогүй өндөр настай хүний тоог тодорхойлно. Өндөр настай ганц бие өрх, нийгмийн даатгалын болон аж ахуйн нэгж байгууллагаас ямар нэг тэтгэвэр, тэтгэмж тогтоогдоогүй өндөр настай хүний тоог гаргахдаа эрэгтэйг 60 ба түүнээс дээш насныхныг, эмэгтэйг 55 ба түүнээс дээш насныхныг авч гаргана.

Хүснэгт 6. Тахир дутуу хүний тоо

Тахир дутуу хүний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлд: Бие бялдар, оюун ухааны чадавхи нь удамшлын болон удамшлын бус шалтгаан, төрөлхийн гажиг, өөрчлөлт, өвчин тарилгын дараах хүндрэл, осол гэмтлийн улмаас алдагдаж, хэвийн нөхцөлд хөдөлмөрлөх чадваргүй болсон, хараа, сонсгол, хэл ярианы болон бие эрхтэний тахир дутуу, оюун санааны хомсдол, сэтгэцийн өөрчлөлттэй болох нь тогтоогдсон Монгол Улсын иргэн, Монгол Улсад хууль ёсоор байнга оршин суугаа гадаадын иргэн, харъяалалгүй хүнийг тахир дутуу хүн гэнэ гэж тодорхойлсон бөгөөд хөдөлмөр магадлах комиссоор тахир дутуу болох нь тогтоогдсон хүнийг авч бүртгэнэ. Мөн үүнээс хүүхдийн тоог салгаж гаргана.